

## **МОНГОЛ-ХЯТАДЫН БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ХАРИЛЦААНЫ ЭХЛЭЛ: БНХАУ-Д СУРАЛЦСАН АНХНЫ МОНГОЛ ОЮУТНУУД (1952-1966)**

*Максимын Хишигтуяа  
ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн  
Email: [khishigtuya\\_m@mas.ac.mn](mailto:khishigtuya_m@mas.ac.mn)*

### **Хураангуй:**

1952-1966 оны хооронд БНМАУ-аас БНХАУ-д 115 оюутан, аспирант, БНХАУ-аас БНМАУ-д 35 оюутан, аспирант, багш мэргэжил дээшлүүлэн суралцсанаар хоёр орны боловсролын салбарын харилцааны эхлэл тавигджээ. Энэ илтгэлд БНХАУ-д суралцах оюутан аспирантын элсэлт, суралцаж байх үеийн хичээл сурлага, аж байдал, хүндрэл бэрхшээл, хоёр орны харилцаа муудаж нутаг буцсан хийгээд тэдний зарим нь шинэ үеийн монголын түүх судлал, хятад судлалын тэргүүлэх эрдэмтэд болсон талаар өгүүлэх болно.

### **Оршил**

1949 оны 10 дугаар сарын 16-нд БНМАУ-БНХАУ дипломат харилцаа тогтоон, улмаар 1952 онд «БНМАУ-БНХАУ-ын хоорондын эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр» байгуулж хэлэлцээрт “эдийн засаг, соёл, гэгээрлийн талаар хамтын ажиллагаа тогтоож, хөгжүүлэн бэхжүүлнэ” гэж заасан. Энэ үеэс хоёр орны соёл, боловсролын салбарын харилцааны эхлэл тавигдаж жил бүр хамтран ажиллах төлөвлөгөө гарган ажиллаж байв. Хэлэлцээрийн дагуу 1952 онд Ч.Далай, Д.Бандихүү, Р.Гүрбазар нарын гурван оюутан Бээжингийн их сургуульд суралцахаар явснаар Монгол-Хятадын боловсролын харилцаа эхэлжээ.

БНХАУ байгуулагдсаны дараа 1950 оноос Польш, Чех, Румын, Албани, Болгар зэрэг Зүүн Европын орнуудын оюутнууд Циньхуа их сургуулийн хятад хэлний бэлтгэл ангид суралцаж эхэлснээр БНХАУ-д гадаад оюутан сурч эхэлсэн байна. 1950-1965 онд нийт 7259 гадаад оюутан<sup>1</sup> суралцсанаас хамгийн олон оюутан суралцуулсан эхний 5 орон:

1. Вьетнам -5252
2. Хойд Солонгос – 546
3. ЗХУ – 208
4. Албани – 194
5. БНМАУ- 131 оюутан сургажээ.

Тухайн үед Хятад улс социалист болон гуравдагч орнуудтай харилцан эдгээр орны сурагчдыг олноор хүлээн авч сургадаг байжээ. БНМАУ ч мөн

<sup>1</sup> 李滔主编, 中华留学教育史录 (1949年以后), 高等教育出版社, 2000年

социалист байгуулалтай орон байсан тул Хятад улстай бүх талын найрсаг харилцаа хөгжүүлж харилцан оюутан сурагчид солилцож байлаа.

Илтгэлд өгүүлэх 1952-1966 оны хооронд БНМАУ-аас нийт 115 оюутан БНХАУ-д очиж суралцсанаас 105 нь дээд сургуульд, 10 нь тусгай мэргэжлийн сургуульд суралцсан байна. Нийт 115 оюутнаас 42 нь сургуулиа төгссөн бол 73 нь элдэв шалтгааны улмаас сургуулиа төгсөөгүй, 2 оюутан нас барж, 2 оюутан гэмт хэрэгт холбогдсон байна. Энэ хугацаанд 9 аспирант суралцсанаас 3 нь (Л.Жамсран, И.Чимэдцэрэн, П.Ядамсүрэн) түүхээр эрдмийн зэрэг хамгаалж бусад 6 нь хамгаалах боломж олдоогүй учраас нутаг буцсан байна. Мөн энэ хугацаанд монгол хэл, утга зохиолын мэргэжлээр 7 багш тус бүр 3 жилийн хугацаатай БНХАУ-д ажиллажээ. (Бадмаараг, Надмид, Жанчивдорж, проф Лувсанвандан нар Бээжингийн их сургуульд, Паля, Лувсанбалдан, Өлзийхутаг нар Хөх хотын дээд сургуульд)<sup>2</sup>.

БНХАУ-ын талаас 1951 оноос эхлэн 27 оюутан, 5 аспирант, мэргэжил дээшлүүлэх 3 багш бүгд 35 хүн МУИС, ХААДС-иудад суралцаж байжээ. Тэднээс МУИС-ийн түүхийн ангийг 5, монгол хэл утга зохиолын ангийг 6 оюутан төгсжээ. 5 аспирантын 3 нь эрдмийн зэрэг хамгаалсан байна. (МУИС-д Бавуудорж, Намжилцэвээн, ХААДС-д Лю Чжен сюе "Төв аймгийн хадлангийн ургацыг дээшлүүлэх ба зөв ашиглах тухай" сэдвээр эрдэмтний зэрэг хамгаалсан). Мэргэжил дээшлүүлэх 3 багшаас Нулмаа 1 жил, Цин Денхуа 4 жил, Хао Ваньжуан 3 жил тус тус ажиллаад буцсан байна<sup>3</sup>.

БНХАУ-д суралцсан эдгээр монгол оюутнуудын дундаас төрөн гарсан багш, эрдэмтэн судлаачдын зохиол бүтээлийн талаар судалгаа, дурсамж зохиолууд олон байдаг. Харин энэ удаагийн илтгэлд тэдний БНХАУ-д суралцахаар явах шалгуураас эхлээд сурлага, сургуулийн орчин, аж байдлын талаар өгүүлэх болно.

### **Оюутнуудын элсэлт ба суралцах журам:**

БНМАУ-аас БНХАУ-д суралцах оюутан шалгаруулахдаа тусгайлан элсэлтийн шалгалт авдаггүй байжээ. Гэхдээ энэ нь огт шалгуургүй гэсэн үг биш бөгөөд дунд сургуулийн сурагч бол онцсайн дүнтэй байх, ажилтан албан хаагч бол ажил сурлагадаа тэргүүний шилдэг байх, сахилга бат, зан төлөв, эрүүл мэнд зэргийг нарийн чанд байцаан шалгадаг байв. Оюутан суралцагсдыг сонгон шалгаруулахдаа доорх асуулгыг авдаг байжээ<sup>4</sup>.

<sup>2</sup> МУУТА., Ф-308, Улсын дээд, тусгай дээд, техник мэргэжлийн боловсролын хороо, Д-1, ХН-95, 148-156-р хуудас

<sup>3</sup> Мөн тэнд. (Тайлбар: Хятад хүний нэрийг архивын материал дээрх тухайн үеийн галигаар бичсэн болно)

<sup>4</sup> МУУТА., Ф-308, Улсын дээд, тусгай дээд, техник мэргэжлийн боловсролын хороо, Д-1, ХН-44

	<b>Гадаадад суралцагчдын анкет</b>
1	Овог нэр
2	Зураг
3	Аль аймаг сум, багийн ямар нэртэй газар хэдэнд онд төрсөн, хэдэн настай
4	Эрэгтэй эмэгтэй
5	Яс угсаа, нийгмийн гарал
6	Одоогийн захиргаа (аймаг, сум, баг, хороо хорин, гудамж хаалга)
7	Ам бүл, таны хэн болох хаана ямар ажилтай
8	Ам бүл тусгай боловч таны ах дүү, садан төрлийн хэн гэгч таны юу болох хаана ямар ажилтай байдаг
9	Та хэдэн оноос хэдэн он хүртэл хэн гэгч хүнтэй гэр бүл болж байсан, одоо таны нөхөр эхнэр хаана ямар ажилтай, хэдэн хүүхэдтэй
10	Та одоо юуны гишүүн
11	Нам эвлэлийн гишүүн эсэх, элссэн он сар
12	Таны өөрийн мал хэдэн оны тооллогоор толгой тус бүр хэд, мөн таны эцэг, эх, ах, дүү нарын мал тус бүр хэдэн толгой, таны малыг хэн маллаж байдаг
13	Таны бие хаана ямар ажлуудыг томилолт ба сонгуулиар хийж байсан, он сараар тодорхой бичнэ үү
14	Та хувьсгалт цэргийн албанд ажиллаж байсан уу, ямар
15	Та дотоод, гадаадын сургууль курст суралцаж байсан уу
16	Тусгай мэргэжил буюу ямар ажилд авьяас дуртай
17	Шинэ хуучин бичгийг аль хир мэдэх
18	Гадаад хэл мэдэх эсэх
19	Нам олон нийтийн сонгуульт ажилтай эсэх
20	Таны эцэг эх садан төрлөөс хувьсгалын өмнө албан тушаалтай байсан эсэх
21	Таны садан төрлөөс лам байсан эсэх
22	Нам эвлэлийн гишүүнээс хөөгдөж, завсардаж байсан ба сануулга авч байсан эсэх
23	Засаг захиргаа хуулийн талаар шийтгэгдэж байсан эсэх
24	Та улсаас гавьяа шагнал алдар цол авсан эсэх
25	Таны эцэг эх садан төрлөөс баригдсан шийтгэгдсэн хүн бий эсэх
26	Та ба таны садан төрлөөс гадаадад явж байсан эсэх, явсан бол хэзээ ямар хэргээр явсан
27	Та одоо хаана ямар ажилтай

Энэ асуулгад түгээмэл асуултуудаас гадна гэр бүл, нийгмийн гарал, өмч хөрөнгийн хэмжээ, гавьяа шийтгэл, нам эвлэлийн гишүүн эсэх зэрэг олон нарийвчилсан асуултууд байгаагаас харахад тухайн үеийн нийгмийн үзэл сурталд нийцүүлэн гадаадад сурах оюутнуудад нарийн шалгуур тавьдаг байжээ.

БНХАУ-ын Дээд Боловсролын яамнаас Хятадад гадаад оюутан суралцах журмын талаар мэдэгдэхдээ:

- Дээд сургуульд орж аспирант хийгчид нь эрхбиш дээд сургууль төгссөн байх бөгөөд манай дээд сургуульд орох оюутан нь эрхбиш бүрэн дунд сургууль төгссөн байна.
- БНХАУ-д ирсэн гадаад оюутнууд хэрэв хятад хэл бичиг мэдэхгүй бол Бээжин их сургуулийн дэргэдэх гадаад оюутны хятад хэл бичгийн тусгай ангид 1-2 жилийн хугацаагаар суралцаж бэлтгэл хийнэ. Үүнд: хятад хэл бичиг, утга зохиол, түүх, философийн тусгай мэргэжлийн хичээл хийгчид нь хятад бичгийг хоёр жилийн хугацаагаар, бусад мэргэжлийн хичээл хийгчид нь нэг жилийн хугацаагаар суралцах болно. Эхний үед лекц яриаг сонсож чадах ба хэвлэл унших чадалтай бөгөөд мөн шалгалтаар тэнцсэн оюутныг дээд боловсролын яамнаас хянаж үзээд тэр оюутны өөрийн нь Засгийн газрын заасан мэргэжлийг баримталж зохих сургуульд хуваарилан оруулж сургана.
- Хятадад ирсэн оюутан нь нийтдээ БНХАУ-ын сургуулийн системийг баримтална. Үүнд: Дээд сургууль нь нийтдээ 4 жил, аспирант 3 жил болно. Хятадад ирсэн оюутан нь хэрэв сурч байгаа хугацааны дундуур мэргэжлээ солихыг хүсэх буюу хугацааг сунгах эсхүл богиносгох бол түүнийгээ эрхбиш өөрийн улсын Засгийн газраас Хятадад суугаа ЭСЯ-аараа дамжуулж БНХАУ-ын Засгийн газартай зөвлөн хэлэлцэж шийдвэрлэж болно.
- Одоо манай улсад аспирант хийж байгаа ба суралцаж байгаа оюутнуудаас манай сургуулийн системээр суралцагсдыг сургууль төгсгөх үед нь төгссөнийг баталсан үнэмлэхийг олгоно. Харин эрдмийн цолны асуудлаар манай улсад одоогоор байхгүй тул сургууль төгсөх үед нь эрдмийн цолыг олгохгүй болно<sup>5</sup> гэж мэдээлснээс тухайн үеийн Хятад улсын сургалтын систем, дүрэм журмын талаар товч ойлголт авч болно.

### **Оюутнуудын мэргэжил сонголт, суралцаж байсан сургуулиуд:**

Хоёр орны хэлэлцээрийн дагуу улсын зардлаар харилцан оюутан сургаж байсан учир байгууллагын нэр дээр салбар бүрд улс оронд хэрэгцээтэй мэргэжлээр оюутан элсүүлдэг байжээ. Аж үйлдвэрийн яам, Худалдааны яам, Хүнсний үйлдвэрийн яам, НАХЯ, Гадаад яам, Соёлын яам, МОНЦАМЭ зэрэг байгууллагуудаас захиалгаар оюутан сургаж байсан баримтууд байна. Энд жишээ болгож 1963 онд тус улсаас БНХАУ-д суралцаж байсан оюутнуудын мэргэжлийн байдал, сургуулийг харуулъя<sup>6</sup>.

<sup>5</sup> Гадаад харилцааны төв архив, Ф-5, Д-2, ХН-160, 151-р хуудас

<sup>6</sup> МУУТА., Ф-308, Улсын дээд, тусгай дээд, техник мэргэжлийн боловсролын хороо, Д-1, ХН-95, 72-р хуудас

<b>Сургуулийн нэр</b>	<b>Тоо</b>
Бээжин их сургууль	13
Бээжин хотын хөнгөн үйлдвэрийн дээд сургууль	4
Бээжин хотын ХАА дээд сургууль	1
Бээжин хотын гадаад хэлний дээд сургууль	2
Ардын их сургууль	2
Ган төмрийн дээд сургууль	2
Үйлдвэрийн урлалын сургууль	1
Гадаад худалдааны дээд сургууль	1
Хөгжмийн дунд сургууль	1
Тяньжиний их сургууль	1
Шанхайн нэхмэлийн дээд сургууль	18
Шанхайн нэхмэлийн дунд сургууль	5
Шанхайн хөгжмийн сургууль	1

<b>Мэргэжлийн нэр</b>	<b>Тоо</b>
Хятад хэл	7
Японхэл	3
Англи хэл	1
Франц хэл	1
Сэтгүүл зүй	2
Гадаад худалдаа	1
Геологи	1
Хөдөө аж ахуй	1
Ган болд	2
Цаас	2
Цардуул, спирт	3
Нэхмэлийн хээ	1
Ноосон нэхмэл	11
Хөвөн нэхмэл	2
Нэхмэлийн будаг	2
Нэхмэлийн машин	3
Хөгжмийн дунд сургууль	2

1963 оны тоо баримтыг харахад Шанхайн нэхмэлийн дээд сургуульд-18, Бээжингийн их сургуульд-13 гэсэн хамгийн олон оюутан сурч байсан бол ноосон нэхмэл мэргэжлээр-18, хятад хэл мэргэжлээр-7 хамгийн олон оюутан сурч байжээ. 1965 онд сурч байсан 36 оюутны 12 нь ноосон нэхмэл, 8 нь хятад хэлний анги үлдсэн сурагчид бусад мэргэжлээр сурч байв<sup>7</sup>. Энэ хоёр мэргэжлээр олон хүн сургаж байсан шалтгаан нь тухайн үед хоёр орон дипломат харилцаа тогтоосон, социалист ахан дүүгийн найрамдалт, олон талт харилцаа хөгжүүлж байсан учир БНМАУ-ын зүгээс хятад хэлтэй, хятадаар мэргэшсэн судлаачид бэлтгэх шаардлага тулгарч байсан мөн үүний зэрэгцээ БНМАУ нь МАА-н орон учраас малын ноос ноолуур боловсруулах үйлдвэрт ажиллах боловсон хүчин бэлтгэх зорилготой байжээ. Үүнээс гадна энэ хугацаанд аспирант сургаж байсан нь Монголд дээд боловсролын салбар байгуулагдаад удаагүй, эрдмийн зэрэг цолтой багшийн тоо хангалтгүй байсантай холбоотой.

<sup>7</sup> МУУТА., Ф-308, Улсын дээд, тусгай дээд, техник мэргэжлийн боловсролын хороо, Д-1, ХН-95, 130-132-р хуудас

## **Оюутнуудын хичээл сурлага ба аж байдал:**

Энэ үед БНМАУ-аас Гадаадад суух ЭСЯ-ууд оюутан сурагчидтай холбоотой бүхий л асуудлыг хариуцан эх оронч, пролетарийн интернационалист үзлээр хүмүүжүүлэх ажлыг хийж, сурлага хүмүүжил, сахилга бат, оюутны тоо бүртгэл, санхүүгийн тооцоог хийж, хувийн хэрэг хөтөлдөг байжээ. Тэд олон улсад болон Монгол улсад болж буй үйл явдал, МАХН-ын тогтоол, шийдвэрүүдийг танилцуулах уулзалт яриа байнга зохион байгуулж, кино үзүүлэх, үдэшлэг зохиох, ном хэвлэлээр тогтмол хангах, Шанхай, Тяньжин, Гуаньжөү хотод суралцаж буй оюутнуудын хичээл сурлага, аж байдалтай танилцах зорилгоор ЭСЯ-ны ажилтнууд биечлэн очиж Хятадын талын багш, холбогдох хүмүүстэй тогтмол уулздаг байжээ.

ЭСЯ-наас Хятадын сургуулиудад жил бүр оюутны сурлагын дүн ба тодорхойлолтыг өгөхийг хүсдэг байсан ч гүйцэд авч чаддаггүй байв. Бээжингийн их сургууль болон зарим сургуулийн цөөн оюутны дүн болон зан байдлын тодорхойлолт бүрэн биш боловч архивд хадгалагдан үлдсэн байна. 1960-аад оноос оюутнуудын тоо олон болохын хирээр сургуулийн шаардлагад тэнцэхгүй муу сурах, хичээл таслах, сургуулиа хаях, гэмт хэрэгт холбогдох зэрэг зөрчил дутагдал олон гарч байв. Оюутнуудын сурлага хангалтгүй байсан учир БНХАУ болон ер нь гадаадад суралцахаар явуулж байгаа хүмүүсийг сайтар судалж шилдэг хүмүүсийг сонгон шалгаруулж байх тухай санал хүсэлтүүд олонтоо гарсан байдаг. Нийт оюутнуудын сурлагын байдлыг харахад аспирантурт сурч байсан хийгээд Бээжингийн их сургуулийн оюутнуудын сурлагын чанар маш сайн байжээ.

ЭСЯ-ны нарийн бичиг, Соёл, боловсролын салбарын хамтын ажиллагаа, харилцааны асуудлыг хариуцсан ажилтан байсан Д.Алмаас дурсахдаа “Тэр үед манай аспирантууд чухам хэдэн юанийн стипенд авдаг байсныг сайн санахгүй байна. Гэхдээ хүрэлцээтэй мөнгө авдаг байсан. Жишээлбэл, Бээжин хотын аль сайн ресторанд ороод нэг юаниар цадталаа идэж болдог байлаа. Бээжингийн их сургуулийн хичээлийн болон оюутан аспирантын суудаг байр тав тухтай, аспирант нар жижиг өрөө тус бүрд нэг нэгээрээ суудаг байлаа. Хятадын тал монгол аспирантуудыг “найрамдалт орны хүмүүс” гэж нэрлэн анхаарал тавьдаг байсан”<sup>8</sup> гэж ярьжээ.

Бээжинд суралцаж байх үеийнхээ амьдралын талаар Хятад хэлний багш, доктор, профессор Л.Маналжав хэлэхдээ “Тухайн үед шинэ Хятад улс байгуулагдаад удаагүй амьдрал хэцүү галладаг байранд хичээл ордог байсан ч монгол оюутнуудыг хамгийн сайн дотуур байранд байлгаж, долоо хоног бүр үзвэр үйлчилгээ, түүх соёлын дурсгалт газруудыг үзүүлдэг байсан. Хамт сурдаг хятад оюутнууд хичээл сурлагын тал дээр онцгой анхаарал тавьж

<sup>8</sup> А.Жамбал, Бээжингийн их сургуулийн аспирантурт суралцсан хүмүүсийн тухайд, Монгол судлалын өгүүллүүд, УБ., 2019. 346-358-р хуудас

тусалж дэмждэг, сайн сурдаг нэг оюутанд биднийг хариуцуулан дагалдуулан сургадаг, өвчтэй хичээлдээ ирж чадаагүй тохиолдолд бүх лекцийг миний дэвтэрт хуулж бичээд өгдөг байсан, багш нар гадаад оюутан гэж ялгалгүй яг хятад оюутантай адил шаардлага тавьдаг байсан”<sup>9</sup> гэж дурссан байдаг.

Оюутны цалин, ахуй хангамжийн талаар 1953 оны БНХАУ-д суралцаж буй монгол оюутны холбогдолтой баримтад өгүүлснээр “БНМАУ ба БНХАУ нь өөрсдийн оюутан аспирант нарыг харилцан сургахдаа сурах зардал, орон сууц, эмнэлэгт үзүүлэх зардал зэргийг оюутан аспирант хүлээн авсан орон хариуцдаг ба хоол хувцас, ном дэвтэр худалдан авах зардал буюу стипенд мөнгийг оюутан аспирант явуулсан орон өөрийн ЭСЯ-аар дамжуулан хангадаг”<sup>10</sup> гэжээ. 1961 оны НТХ-ны Сайд нарын зөвлөлийн №190 тогтоолын хавсралтад “БНХАУ-д сурдаг оюутан 100 юань, аспирант 175 юань авна”<sup>11</sup> гэж тогтоожээ. Дээр өгүүлсэн дурсамж яриа, Л.Жамсрангийн өдрийн тэмдэглэлээс<sup>12</sup> харахад оюутнуудын авдаг сарын цалин нь тэдний амьдралд хүрэлцдэг байсан бололтой.

### **Оюутнуудад тулгарч байсан хүндрэл бэрхшээл:**

Тухайн үеийн Хятадын дээд боловсрол, аспирантурын сургалтын төлөвшилтэй холбоотой аспирантурт суралцаж байгаа зарим хүмүүс сэдэв сонгох, архивын материал ашиглах явдал дээр нэлээд саад тохиолдож байжээ. Тухайлбал: “1958 онд ирсэн аспирант Жүгдэр XVII зууны үеийн Монголын шашны философи сэдвээр цол хамгаалах зорилготой иржээ. Гэтэл хятад нөхөд хэлэхдээ манайд Буддын шашны философиор эрдэм шинжилгээний газар байхгүй тул уг сэдвийг хүлээн авахад хэцүү байна гэх зэргээр түүний ажлыг удирдах хүн гаргаж өгөхгүй буюу холбогдох материалыг судлуулахгүй байна. Аспирант Чимидцэрэн XIV-XV зууны үед Хятадын эргэн тойрон байсан улсуудын тухай тэмдэглэл гэдэг 8 боть зохиол дээр голлон ажиллаж цол хамгаалах зорилгыг тавьж байна. Уг зохиолыг судлахад хуучин хятад хэл сайн мэддэг эрдэм шинжилгээний удирдагч хэрэгтэй атал түүнд одоо цагийн хэлээс өөр юм мэддэггүй 4-р ангийн нэг оюутан удирдагчаар гаргаж өгсөн байна. Аспирант Ишжамц нь 1755-1758 оны Монголын ард түмний тусгаар тогтнолын тэмцэл гэдэг сэдвээр цол хамгаалахаар 56 онд ирсэн бөгөөд энэ оны 5-6 сард уг цолоо хамгаалаад буцах ёстой. Гэтэл архивын зарим чухал материалаа үзүүлэх зөвшөөрөл

<sup>9</sup> Доктор, профессор Л.Маналжавтай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс, 2019.06.29.

<sup>10</sup> Гадаад харилцааны төв архив, Ф-5, Д-2, ХН-217.

<sup>11</sup> Гэгээрэл шинжлэх ухаан соёлын талаар холбогдолтой хуульчилсан актуудын системчилсэн эмхэтгэл (1961-1963), Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо (Эмхэтгэсэн Б.Жамьян), УБ., 1964. 110-112-р хуудас

<sup>12</sup> Монголоо гэсэн эрдэмтний өв, Хоёр: Л.Жамсрангийн өдрийн тэмдэглэлээс, I. Бээжинд суралцахаар очсон эхний жилийн өдрийн тэмдэглэл (1957.9.7-1958.7.4), УБ., 2019. 193-266-р хуудас

өгөхгүй байгаагаас хугацаандаа цолоо хамгаалалгүй намар эргэж ирэхээр буцжээ. XVI-XVII зууны эцсийн Монголын түүхтэй холбогдол бүхий Ван Лий хааны дайны гавьяаны тэмдэглэл гэдэг зохиолоор цол хамгаалах гэж байгаа аспирант Л.Жамсранд эрдэм шинжилгээний ажлыг нь удирдах хүн олдоогүй байна. Үүнээс үзвэл Хятадад түүхийн сэдвээр аспирант ирүүлэх цол хамгаалах явдал төдий л сайн биш талтай байгааг хойшид харгалзан үзэх нь зүйтэй”<sup>13</sup> гэж Элчин сайд Д.Шарав илтгэлдээ дурджээ. Мөн “аспирант Г.Сүхбаатар, Ц.Санжаасүрэн нар Бээжингийн их сургуульд хэлний бэлтгэл хийгээд 2 жил болсон. Энэ хоёр өнгөрсөн хугацаанд намраас эхлээд жинхэнэ аспирант ёсоор ажиллах ёстой. Гэтэл тэд их сургуулийн 1-4 ангиудын зарим хичээлд сууж байдаг” талаар ярьж энэ хоёр аспирантын цаашдын ажлыг зохих ёсоор хийлгүүлэхэд туслахыг хүссэн боловч нааштай үр дүнд хүрээгүй, мөн үед аспирантурт сурч байсан Паля, Түмэнжаргал нар 1962 оны 9 дүгээр сараас Хятадад эргэж суралцахгүй болжээ<sup>14</sup>гэх зэрэг баримтууд байна. Тухайн үед хоёр орон түүхийн зарим асуудлуудаар нэгдмэл байр сууринд хүрээгүй байснаас түүхийн чиглэлээр аспирант сургахад хүндрэл учирч байжээ.

Үүнээс гадна хичээлийн хөтөлбөрийн дагуу дадлага хийх ёстой оюутнуудад дадлага хийлгэхгүй байх, дадлагад зөвхөн хятад оюутнууд хамрагдана, гадаад хүн очих хориотой бүс нутаг гэх мэтийн шалтаг хэлэх явдал олон давтагдаж байв.

Монгол сурагчдын хувьд ч сургуулийн шаардлагад тэнцэхгүй байх, суурь боловсрол эзэмшээгүй баримт бичгийг хуурамчаар үйлдэх, улс оронд шаардлагагүй болон Хятад улсад бэлтгэдэггүй мэргэжлээр суралцахаар ирэх зэргээр оюутны тоо олшрох тусам элсэлтийн шалгуур суларч, зөрчил дутагдал ихээр гарах болсон. Иймд Бээжинд суух ЭСЯ-ны илтгэх бичигт Хятад улсад ямар мэргэжлээр, ямар хүнийг сургах талаар нарийн судалгаа хийж шаардлагатай мэргэжлээр хүн элсүүлэх асуудлаар сайтар судалгаа хийнэ үү гэсэн хүсэлтийг тавьж байжээ.

### **Оюутнууд нутаг буцсан нь:**

Өгүүлэн буй үед БНМАУ, БНХАУ хоёр ЗХУ тэргүүтэй социалист лагерийн орнууд байв. 1960-аад оноос ЗХУ, БНХАУ-ын харилцаа муудсан нь БНМАУ, БНХАУ-ын харилцаанд ч нөлөөлж эхэлсэн. Манай ЭСЯ-ны оюутны асуудал эрхэлсэн хүмүүсийн санал хүсэлтийг үл ойшоох, оюутнуудыг сурлагаар хавчин гадуурхах хандлагатай болжээ. Түүнчлэн 1966 оноос Хятадад “Соёлын хувьсгал” эхэлж, дээд боловсролын байгууллагууд хаагдаж, Хятадад

<sup>13</sup> Гадаад харилцааны төв архив, Ф-5, Д-2, ХН-217, 30-41-р хуудас

<sup>14</sup> А.Жамбал, Бээжингийн их сургуулийн аспирантурт суралцсан хүмүүсийн тухайд, Монгол судлалын өгүүллүүд, УБ., 2019. 346-358-р хуудас

сурч байсан гадаад улсын оюутнууд бүгд нутаг буцсан. Монгол оюутнууд ч сургуулиа түр зогсоож буцсан. Энэ талаар "1966 оны 9 дүгээр сарын 19-нд Хятадын дээд боловсролын яам манай ЭСЯ-нд өгсөн санамж бичигтээ: Соёлын их хувьсгал явагдаж байна. Хятадад сурч байгаа гадаадын оюутныг нэг жилийн хугацаагаар эх оронд нь буцаахаар шийдлээ гэснээр манайх 12 оюутнаа татаж ирүүлээд Улсын их сургуулийн дэргэд сургалтын тусгай төлөвлөгөө программаар хятад хэлний орчуулагчийн групп байгуулж 1 жилийн дараа төгсгөх, заримыг нь ЗХУ-д япон, испани хэлний зохих ангид үргэлжлэн сургах хүртэл арга хэмжээ авсан юм. Одоо Хятадтай тус хорооны шугамаар ямар нэгэн харилцаа байхгүй, харин манай иргэн Насанжав Хятадын хуулиар 17 жил хоригдох ял эдэлж Шанхайд байгаа<sup>15</sup> гэж илтгэж байжээ.

### **Зарим оюутан, аспирантуудын амжилтын тухай:**

1952-1966 онд БНХАУ-д сурсан оюутнууд, аспирантуудаас Монголын хятад судлал, хятад хэлний сургалт, орчуулга, Монголын түүхийн судалгаанд үнэтэй хувь нэмэр оруулсан эрдэмтэн багш нар, дипломатчид цөөнгүй байдаг. Тухайлбал:

- Шинжлэх ухааны Гавьяат зүтгэлтэн, Академич Ч.Далай
- Шинжлэх ухааны Гавьяат зүтгэлтэн, Академич Н.Ишжамц
- Шинжлэх ухааны Гавьяат зүтгэлтэн, Түүхийн шинжлэх ухааны доктор, профессор Л.Жамсран
- Академич Ч.Жүгдэр (философич)
- Гавьяат багш, Хэл шинжлэлийн ухаан доктор, профессор Чой. Лувсанжав
- Хэл шинжлэлийн ухааны доктор, профессор Л.Маналжав
- Түүхийн ухааны доктор Гүнжийн Сүхбаатар
- Ардын жүжигчин, Төрийн хошой шагналт хөгжмийн зохиолч Б.Дамдинсүрэн (Монгол Улсын төрийн дууллыг зохиосон)
- Ардын боловсролын яамны орлогч сайд асан, доктор Ц.Санжаасүрэн
- Дэд эрдэмтэн, доцент, МУИС-ийн хүндэт профессор И.Чимэдцэрэн
- Төв Музейн захирал асан, доктор П.Ядамсүрэн нарыг дурдаж болно.

### **Хятад хэлний сургалт, орчуулгын талаар:**

1957 онд МУИС-д хятад хэлний анги нээгдэж Бээжингийн их сургуулийг төгсөөд ирсэн Чой.Лувсанжав, Р.Нямаасүрэн, О.Адьяа, Л.Маналжав, Ч.Далай нар хятад хэл, хятадын уран зохиол, хятадын түүхийн хичээл заадаг байв. Эдгээр анхны хятад судлаачид хэл заахаас гадна уран зохиолын орчуулга,

<sup>15</sup> МУУТА., Ф-308, Улсын дээд, тусгай дээд, техник мэргэжлийн боловсролын хороо, Д-1, ХН-95, 94-р хуудас

хятад хэлний сурах бичиг, гарын авлага зохиох ажлыг хийсэн байна. Чой. Лувсанжав «Монгол-Хятад ярианы дэвтэр» 1,2 ботийг бичсэн. Бээжингийн их сургуулийн төгсөгч Д.Бандихүү, Чой.Лувсанжав нар хятадын алдарт зохиолч Лү Шюний өгүүллэгүүдийг орчуулан «Мөнх гийгүүлэгч дэнлүү» өгүүллийн түүвэр болгон гаргаж байжээ<sup>16</sup>.

### **Хятад судлалын талаар:**

1968 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны тогтоолоор ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын дэргэд Ази, Африкийг судлах хэлтэс байгуулж улмаар 1976 оны 12 дугаар сард Дорно дахины судлалын хүрээлэн болгон өргөжүүлэхэд энэ байгууллагын даргаар Ч.Далай ажиллан, эрдэмтэн судлаачаар Н.Ишжамц, Г.Сүхбаатар, Л.Жамсран нарын Бээжингийн их сургуульд сурч байсан оюутан аспирантууд ажиллан орчин цагийн Монголын хятад судлалын үндсийг тавьж, Хятад судлалаар олон арван бүтээл туурвижээ.

### **Монголын түүх судлалын талаар:**

БНХАУ-д түүхийн мэргэжлээр аспирантурт суралцсан доорх хүмүүсийг Монголын түүхийн долоо гэж нэрлэдэг.



*Зүүн гар талаас нэг дэх эгнээ: Г.Сүхбаатар, И.Чимэдцэрэн, Н.Ишжамц, хоёр дахь эгнээ: Ч.Жүгдэр, П.Ядамсүрэн, Ц.Санжаасүрэн, Л.Жамсран*

<sup>16</sup> Н.Ариунгуа, Ч.Батцэцэг, Монгол дахь Хятад судлал, Олон улс судлал сэтгүүл, 2006№4(74)

Монголын түүхийн анхдагч бичгийн сурвалжууд хятад хэл дээр байдаг. Хятадад суралцан хятад хэл сурсан тэд дээрх сурвалжуудыг ашиглан Монголын түүхийг нэн эртнээс XX зуун хүртэл судалж, Монголын түүхийн тулгуур зохиолуудыг бичсэн байна. Дээр өгүүлсэн тодорхой шалтгааны улмаас зарим аспирант нь сургуулиа төгсөөгүй ч Монголд буцаж ирэн эрдмийн зэрэг цолоо хамгаалж хийсэн бүтээл, ажил хөдөлмөрөөрөө нэрд гарсан эрдэмтэд болсон.

### **Дүгнэлт**

Боловсролын салбарын харилцаа хамтын ажиллагаа нь ард иргэдийн харилцан ойлголцлыг нэмэгдүүлэх нэг чухал арга хэлбэр болдог. Хоёр орон 1949 онд дипломат харилцаа тогтоосноор социалист ах дүүгийн найрамдалт харилцаа хөгжүүлж байлаа. 1952-1966 оны хооронд БНМАУ-аас БНХАУ-д 115 оюутан, аспирант, БНХАУ-аас БНМАУ-д 35 оюутан, аспирант, багш солилцон суралцуулснаар хоёр орны боловсролын салбарын харилцааны эхлэл тавигджээ. Эхэн үедээ Хятадад сурах оюутны элсэлт маш чанартай явагддаг байсан бол жил ирэх тусам хүний тоо олширч хяналт сулран суурь боловсрол эзэмшээгүй, муу сурлагатай оюутнууд сурахаар очих, шаардлагагүй мэргэжлээр сурах, гэмт хэрэгт холбогдох зэрэг асуудал гарах болсноор нийт оюутнуудын 50 хүрэхгүй хувь нь сургуулиа төгссөн байдаг. Тэдний дунд хятад хэл болон ноосон нэхмэлийн мэргэжлээр хамгийн олон оюутан суралцаж байжээ. Хоёр орон түүхийн зарим асуудлаар санал зөрөлдөөнтэй байсан учир түүхийн аспирантуудын олонх нь төгсөөгүй ба бусад хүндрэл бэрхшээлүүд ч тулгарч байжээ. 1960-аад онд ЗХУ-БНХАУ-ын харилцаа муудан, БНХАУ-д Соёлын хувьсгал эхлэн гадаад орны оюутнууд бүгд нутаг буцсанаар харилцаа тасарсан байдаг.

Энэ хугацаанд суралцсан нийт оюутан, аспирантуудын дундаас Монголын шинэ үеийн алдартай хятад судлаач, хэлний нэрт эрдэмтэн багш нар, монголын түүх судлаач, философич, гадаад харилцааны ажилтнууд олноор төрөн гарсан бөгөөд тэд болон тэдний шавь нар хоёр улсын соёл боловсрол, шинжлэх ухааны салбарын найрамдалт харилцааг хөгжүүлэхэд чухал хувь нэмрээ оруулсаар ирсэн. Харин технологийн чиглэлээр суралцсан оюутнууд төгсөж ирээд ямар ажил төрөл эрхэлж байсан талаар мэдээлэл бага, энэ асуудлыг цаашид судлах шаардлагатай байна.

Монгол-Хятадын боловсролын салбарын харилцаа нэгэнт 70 жил болсон ч өмнөх үеийн асуудал хэвээр байсаар байна. Өмнөх үеийн алдаанаасаа суралцан Хятад улсад суралцах оюутан элсүүлэхдээ улс оронд эн тэргүүнд хэрэгцээтэй мэргэжлээр, элсэлтийг өндөр түвшинд зохион байгуулж, Хятад улсад ямар мэргэжлээр оюутан сургавал ашигтай эсвэл ашиггүй байх талаар анхаарч ажиллах хэрэгтэй байна.

### **Ашигласан материал:**

1. *Монгол Улсын Үндэсний төв архив, БНМАУ-ын Гэгээрлийн яам, Улсын дээд, тусгай дээд, техник мэргэжлийн боловсролын хорооны фонд-308, Данс-1, ХН-44, 95-р хуудас*
2. *Монгол Улсын Гадаад харилцааны яамны төв архив, Фонд-5, Данс-2, ХН-160, 217-р хуудас*
3. *Монгол-Хятадын соёл, шинжлэх ухааны харилцаа (1949-1965 он). Баримт бичгийн эмхэтгэл. УБ., 2021.*
4. *Гэгээрэл шинжлэх ухаан соёлын талаар холбогдолтой хуульчилсан актуудын системчилсэн эмхэтгэл (1961-1963), Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо, (Баримт бичгийн эмхэтгэл. Эмхэтгэсэн Б.Жамьян) УБ., 1964.*
5. *Н.Ариунгуа, Ч.Батцэцэг, Монгол дахь хятад судлал, Олон Улс Судлал сэтгүүл, 2006№4(74)*
6. *А.Жамбал, Бээжингийн их сургуулийн аспирантурт суралцсан хүмүүсийн тухайд. Монгол судлалын өгүүллүүд, УБ., 2019. 346-358-р хуудас*
7. *Доктор, профессор Л.Маналжавтай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс, 2019.06.29.*
8. *Монголоо гэсэн эрдэмтний өв, Хоёр: Л.Жамсрангийн өдрийн тэмдэглэлээс. I. Бээжинд суралцахаар очсон эхний жилийн өдрийн тэмдэглэл (1957.9.7-1958.7.4), УБ., 2019. 193-266-р хуудас*
9. *中华留学教育史录 (1949年以后), 高等教育出版社, 李滔主编, 2000年*
10. *程家福, 来华留学生教育结构历史研究 (1950-2010), 同济大学出版社, 2012.*